



## НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

┌ Тушаал хүчингүй болгож, ┐  
└ журам шинэчлэн батлах тухай ┘

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйл, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдах авах тухай хууль, Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм батлах тухай” 178 дугаар тушаал, Засгийн газрын 2017 оны “Дүрэм батлах тухай” 170 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 316 дугаар тогтоол, 2019 оны Дүрэм шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 108 тогтоол, Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 170 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн “Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх журам”-ыг нэгдүгээр, баримт бичгийн бүрдэл маягтуудыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэхүү журмыг мөрдөн ажиллахыг нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-д даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/50 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Б.МӨНХБАТ

3150800200

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
даргын 2023 оны 04 дугаар сарын 03-ны  
өдрийн 01/56 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИК ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар “ОНӨААТҮГ” (цаашид “газар” гэх)-ын Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах, ажлын уялдаа холбоог сайжруулах, ажил үүргийн хуваарийг оновчтой тогтооход энэ журмын зорилго оршино.

1.2. Техник хяналт нь Зөвлөх үйлчилгээний техник хяналт, Барилгын ажлын техник хяналт гэсэн үндсэн хэсгээс бүрдэнэ. Барилгын ажлын техник хяналт гэж Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-д заасныг (цаашид “барилгын ажил” гэх), Зөвлөх үйлчилгээний техник хяналт гэж Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д заасан (цаашид “Зөвлөх үйлчилгээ” гэх) ажилд техник хяналт хийх үйл ажиллагаа гэж тус тус ойлгоно.

1.3. Техник хяналтыг хэрэгжүүлэхэд Барилгын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Барилгын ажлын захиалагчийн дүрэм, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм, Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах журам, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, энэ журам болон холбогдох бусад хууль, эрх зүйн актыг мөрдөнө.

### Хоёр. Зөвлөмж хүлээн авах үе шат

2.1. Хууль, дотоод хяналтын хэлтэс үнэлгээний хорооноос ирүүлсэн зөвлөмж, холбогдох материалыг хүлээн авч хянан шалгаад зөвлөмжийг буцаах эсвэл Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн гэрээ байгуулна.

2.2. Шаардлага хангаагүй тохиолдолд тендерийн баримт бичгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээний хороонд албан тоотор буцаана.

### Гурав. Гэрээ байгуулах үе шат, гэрээ сунгалтын үе шат

3.1. Гүйцэтгэгчтэй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан тендерийн хүчинтэй хугацаанд гэрээ байгуулна.

3.2. Гэрээг Зураг төсвийн ажлын гэрээний баримт бичгийн бүрдэл Маягт 1<sup>1</sup>, Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний баримт бичгийн бүрдэл Маягт 1<sup>2</sup>-т заасан материалыг бүрдүүлэн Зураг төсвийн ажлын гэрээний хяналтын карт-Маягт №3<sup>3</sup>, Барилгын ажлын гэрээний хяналтын карт-Маягт №3<sup>4</sup>-т заасны дагуу хийн Хууль дотоод хяналтын хэлтсийн дарга, Зураг төслийн хэлтсийн дарга, (түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ажилд) Барилга захиалагчийн хэлтсийн дарга,



Санхүү аж ахуйн хэлтсийн дарга, Ерөнхий инженер нар хянаж баталгаажуулсаны дараа Газрын дарга албажуулна.

3.3.Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-аар албажсан гэрээг захиалагч (Нийслэлийн засаг даргын тамгын газар)-т хүргүүлэн батлуулна.

3.4.Захиалагчаас батлагдаж ирсэн гэрээг Барилга захиалагчийн хэлтсийн дарга болон Зураг төслийн хэлтсийн дарга хяналтын инженерт хувиарлана.

3.5.Сунгалтын гэрээг Маягт 1<sup>4</sup>-т заасан материалыг бүрдүүлж Маягт 3<sup>3</sup>, Маягт 3<sup>4</sup>-ийн дагуу тус тус хяналтын карт хийн баталгаажуулна.

### **Дөрөв.Зөвлөх үйлчилгээний техник хяналт**

4.1.Эхний шатны тайланд захиалагчийн хяналт тавих:

4.1.1.Зураг төслийн хэлтэс нь зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан ажилд техник хяналт тавина.

4.1.2.Гүйцэтгэгч батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаварын дагуу инженер геологийн дүгнэлт, байр зүйн дэвсгэр зураг, эскиз зураг төслийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар “Дүрэм шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоолын хавсралт “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн дагуу шаардлагатай байгууллагуудтай зөвшилцсөн эсэхийг хяналтын инженер хянана.

4.1.3.Хяналтын инженер эскиз зураг төслийг архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу хийгдсэн эсэхийг шалгаж Маягт № 7<sup>2</sup>-ийн дагуу ахлах инженер, хэлтсийн дарга, Ерөнхий инженерт танилцуулан, газрын даргаар баталгаажуулж ажлын 2 өдрийн дотор гүйцэтгэгч байгууллагад хүлээлгэн өгнө.

4.1.4.Гадна инженерийн шугам сүлжээний ажлын зургийг эхлэхдээ трассыг Хот байгуулалт, Хөгжлийн газар, ашиглагч, хангагч байгууллагуудтай зөвшилцөх ажлыг зургийн зохиогч шаардлагатай үед хариуцсан хяналтын инженертэй хамтран гүйцэтгэнэ.

4.1.5.Хяналтын инженер, батлагдсан эскиз зураг, шугам сүлжээний трасс, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, засварын ажлын хэмжилтийн зургийг үндэслэн гүйцэтгэгчид ажлын зураг төслийн ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгоно.

4.1.6.Гэрээний тусгай нөхцөлд заасан эхний санхүүжилт олгох гүйцэтгэлийг Маягт №2<sup>1</sup> “Зураг төсвийн ажлын санхүүжилт олгох гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдэл”-ийн дагуу НХОГ-ын Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн хүлээн авч ажлын 1 өдөрт багтаан хариуцсан хяналтын инженерт шилжүүлнэ. Хяналтын инженер энэ журмын хавсралт Маягт №3<sup>1</sup> “Зураг төсвийн ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”-ын дагуу ажлын 4 хоногт багтаан ахлах инженер, хэлтсийн дарга, Санхүү аж ахуйн хэлтэс, Хууль дотоод хяналтын хэлтэс, Ерөнхий инженерээр хянуулан баталгаажуулсныг газрын дарга албажуулна.

4.1.7.Гүйцэтгэл баталгаажих явцад засвар оруулах тохиолдолд хавсралт Маягт №7<sup>1</sup>-ийн дагуу Хяналтын хуудас хөтөлж хяналтын инженер гүйцэтгэгчид буцаана.

4.1.8.Гүйцэтгэлийн хяналтын картыг Маягт №3<sup>1</sup> дагуу 2 хувь үйлдэж, нэг хувийг Санхүүгийн мэргэжилтэн архивын нэгж болгон хадгална.

4.2. Зураг төсөл боловсруулах ажлын хяналт тавих:

4.2.1. Хяналтын инженер батлагдсан эскиз зураг, архитектур төлөвлөлтийн даалгавар, ажлын зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу шаардлагатай техникийн үзүүлэлтийг гүйцэтгэгчээс гаргуулан авч, ажлын 2 хоногийн дотор хангагч байгууллагууд руу техникийн нөхцөл хүссэн албан тоот хүргүүлнэ. Техникийн нөхцөл гаргуулах ажлыг хяналтын инженер, ахлах инженер, хэлтсийн дарга нар хамтран зохион байгуулна. Хангагч байгууллагаас техникийн нөхцөл баталгаажсан өдөрт нь багтаан гүйцэтгэгчид хүргүүлнэ.

4.2.2. Техникийн нөхцөлүүд шийдвэрлэгдэх хугацаанд хариуцсан хяналтын инженер дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- a. техникийн нөхцлүүд баталгаажсан даруй хариуцсан хяналтын инженер гадна шугам сүлжээний ажлын зургийг эхлүүлэх зөвшөөрөл өгч, холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний дагуу нэгдсэн хяналтын төсөв хийлгэж, иж бүрэн дууссан ажлын зураг төсвийг хүлээн авч, чиглэл тус бүрээр хариуцсан инженерүүдэд тараан өгч ажлын 3 өдрийн дотор хянуулна,
- b. хариусан инженер Маягт №6 -ын дагуу санал зөвлөмжөө гүйцэтгэгч байгууллагад хүргүүлэн, хуанлийн 3-5 хоногийн дотор шаардлагатай засвар өөрчлөлтийг гүйцэтгүүлэх үүрэг даалгавар өгч зөрчлийг арилгуулна.

4.2.3. Иж бүрэн боловсруулсан, ажлын зураг төсөв нь Шаардлага хангасан тохиолдолд хяналтын инженер, ахлах инженер, хэлтсийн дарга, Ерөнхий инженерээр хянуулан гарын үсэг зуруулж, Маягт 7<sup>2</sup> дагуу газрын даргаар баталгаажуулан ОБЕГ, НОБГ, НЭМГ-ын дүгнэлт болон Магадлалын дүгнэлт гаргуулахаар холбогдох байгууллага руу албан тоот бичгээр хүргүүлнэ.

4.2.4. Хяналтын инженер нь зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын явцад гэрээний биелэлтэд хяналт хийхээс гадна техникийн шийдэл, техник эдийн засгийн тооцооны явцад мөрдөгдөж байгаа БНБД-ийн хүрээнд хяналт тавьж, гүйцэтгэгчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч заавал зөвшилцөх байгууллагуудтай зөвшилцөх явцад хамтран ажиллана.

4.2.5. Хяналтын инженер нь зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх явцад “Техникийн зөвлөлийн ажиллах журам”-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд “Техникийн зөвлөлийн хурал”-аар оруулан шийдвэрлүүлж, шийдвэрийг холбогдох газруудад ажлын 2 хоногийн дотор хүргүүлнэ.

4.2.6. Хяналтын инженер ажлын явцын мэдээллийг хөрөнгө оруулалтын мэдээллийн системд 7 хоног тутам оруулах бөгөөд ахлах инженер, хэлтсийн дарга хянаж байна.

4.2.7. Гэрээний тусгай нөхцөлд заасан явцын санхүүжилт олгох гүйцэтгэлийн бичиг баримтын бүрдлийг Маягт №2<sup>1</sup> “Зураг төсвийн ажлын санхүүжилт олгох гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдэл”-ийн дагуу НХОГ-ын Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн хүлээн авч ажлын 1 өдөрт багтаан хариуцсан хяналтын инженерт шилжүүлнэ.

4.2.8. Хяналтын инженер шалган Маягт 3<sup>1</sup>-д заасан холбогдох албан тушаалтнуудаар гарын үсэг зурж баталгаажуулсны дараа газрын дарга албажуулна.



4.2.9. Гүйцэтгэл баталгаажих явцад засвар оруулах тохиолдолд хавсралт Маягт №7<sup>1</sup>-ийн дагуу хяналтын хуудас хөтлөн хяналтын инженер гүйцэтгэгчид буцаана.

4.2.10. Гүйцэтгэлийн хяналтын картыг Маягт №3<sup>1</sup> дагуу 2 хувь үйлдэж, нэг хувийг Санхүүгийн мэргэжилтэн архивын нэгж болгон хадгална.

4.3. Зураг, төсөл хүлээн авах эцсийн үе шат

4.3.1. Магадлал хийгдсэн ажлын зураг төслийг Маягт №5<sup>1</sup> “Магадлал хийгдсэн ажлын зураг төслийг хүлээлцсэн акт”-ын дагуу гэрээнд заасны дагуу эх хувь -1, CD дээр бичигдсэн файл хэлбэрээр хариуцсан хяналтын инженер, ахлах инженер, хэлтсийн дарга гарын үсэг зурж хүлээн авна.

4.3.2. Хяналтын инженер энэ журмын хавсралт Маягт №4<sup>1</sup> “Зураг төсвийн ажлын гэрээ дүгнэсэн протокол”-ын дагуу гэрээг дүгнэн, проткол үйлдэж ахлах инженер, хэлтсийн дарга, санхүү аж ахуйн хэлтсийн дарга, Хууль дотоод хяналтын хэлтэс болон гүйцэтгэгч компаниар баталгаажуулан гарын үсэг зурснаар ажлыг дуусгана.

4.3.3. Хяналтын инженер зураг төслийг ажлын 2 хоногт хөрөнгө оруулалтын мэдээллийн системд оруулах бөгөөд шаардлагатай тохиолдолд зураг төслийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, дүүргүүд болон бусад байгууллагуудад журмын хавсралт Маягт №5<sup>2</sup> “Зураг төсөв хүлээлцэх акт”-аар ажлын 3 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

4.3.4. Барилга захиалагчийн хэлтэст шууд хүлээлгэн өгөх тохиолдолд объект хариуцсан хяналтын инженер, ахлах инженер, хэлтсийн дарга болон Зураг төслийн хэлтсийн хариуцсан инженер, ахлах инженер, хэлтсийн дарга хянаж журмын хавсралт Маягт №5<sup>2</sup> “Зураг төсөв хүлээлцэх акт”-ын дагуу хүлээлцэж шилжүүлнэ.

4.3.5. Зураг төсвийн ажлын техникийн баримт бичгийн бүрдлийг журмын хавсралт Маягт №8<sup>1</sup> “Зураг төслийн ажлын баримт бичгийн бүрдэл”-ийн дагуу бүрдүүлэн ажил дууссан улиралд багтаан архивын нэгж болгон архивт хүлээлгэж өгнө.

4.3.6. Гэрээний тусгай нөхцөлд заасан эцсийн санхүүжилт олгох гүйцэтгэлийн бичиг баримтын бүрдлийг Маягт №2<sup>1</sup> “Зураг төсвийн ажлын санхүүжилт олгох гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдэл”-ийн дагуу НХОГ-ын Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн хүлээн авч ажлын 1 өдөрт багтаан хариуцсан хяналтын инженерт шилжүүлнэ.

4.3.7. Хариуцсан хяналтын инженер энэ журмын хавсралт Маягт №3<sup>1</sup> “Зураг төсвийн ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”-ын дагуу ажлын 4 хоногт багтаан холбогдох албан тушаалтнуудаар хянуулж гарын үсэг зуруулж баталгаажуулсны дараа газрын дарга албажуулна.

4.3.8. Гүйцэтгэл баталгаажих явцад засвар оруулах тохиолдолд хавсралт Маягт №7<sup>1</sup>-ийн дагуу Хяналтын хуудас хөтлөн хяналтын инженер гүйцэтгэгчид буцаана.

4.3.9. Гүйцэтгэлийн хяналтын картыг Маягт №3<sup>1</sup> дагуу 2 хувь үйлдэж, нэг хувийг Санхүүгийн мэргэжилтэн архивын нэгж болгон хадгална.

**Тав.Барилга угсралтын ажилд тавих хяналт**

5.1.Барилга захиалагчийн хэлтсээс барилгын ажилд захиалагчийн техникийн хяналт гүйцэтгэнэ. Ажил эхлүүлэх, ажлын явцад хяналт тавих, ажил дуусгах гэсэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.2.Барилгын ажил эхлүүлэх үе шат

5.2.1.Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зөвшөөрөл олгох дүрэм”-ийн дагуу холбогдох бичиг баримтыг бүрдүүлж Хот байгуулалт хөгжлийн газарт албан бичгээр хандан зөвшөөрлийг гаргуулан гүйцэтгэгч байгууллагад хүлээлгэн өгнө.

5.2.2.Шаардлагатай тохиолдолд барилгын ажлын талбайг холбогдох байгууллагатай хамтарч чөлөөлүүлэх, газар шорооны ажил эхлэхээс өмнө холбогдох дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний байгууллагуудад мэдэгдэж зөвшөөрөл авах ажлыг гүйцэтгэгчтэй хамтран хяналтын инженер, бүсийн ахлах инженер, хэлтсийн дарга, Зураг төслийн хэлтсийн хяналтын инженерүүд зохион байгуулна.

5.2.3.Хяналтын инженер барилгын ажлын зургийн хуулбарыг дардас дарж, баталгаажуулан гүйцэтгэгч байгууллагад хүлээлгэн өгнө.

5.2.4.Хяналтын инженер, бүсийн ахлах инженер нар барилгын талбайд ажил эхлүүлэх тухай тэмдэглэл үйлдэн, улаан шугам татаж, тэг тэнхлэг байгуулах актыг гүйцэтгэгч болон геодезийн мэргэжлийн байгууллагаар баталгаажуулан мэдээллийн санд оруулж барилгын ажлыг эхлүүлнэ.

5.2.5.Хяналтын инженер нь барилгын ажил явагдаж байгаа талаар тайлбартай самбар (анхааруулга самбар) байрлуулах, стандарт хангасан хашаа бариулах, барилга угсралтын ажлын үед орчны аюулгүй ажиллагаа хангах ажлыг БНБД болон бусад хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу гүйцэтгэгч байгууллагаар заавал хийлгүүлнэ.

5.2.6.Гүйцэтгэгчээс ирүүлсэн эхний санхүүжилт хүссэн гүйцэтгэлийг Маягт №2<sup>2</sup> “Барилга угсралтын ажлын (эхний болон явцын) гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдэл”-ийн дагуу НХОГ-ын Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн хүлээн авч ажлын 1 өдөрт багтаан хариуцсан хяналтын инженерт шилжүүлнэ.

5.2.7.Хяналтын инженер энэ журмын хавсралт маягт №3<sup>2</sup> “Барилгын ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”-ын дагуу ажлын 4 хоногт багтаан ахлах инженер, хэлтсийн дарга, Санхүү аж ахуйн хэлтэс, Хууль дотоод хяналтын хэлтэс, Ерөнхий инженерээр хянуулан баталгаажуулсныг газрын дарга албажуулна.

5.2.8.Гүйцэтгэл баталгаажих явцад засвар оруулах тохиолдолд хавсралт маягт №7<sup>1</sup>-ийн дагуу Хяналтын хуудас хөтлөн хяналтын инженер гүйцэтгэгчид буцаана.

5.2.9.Гүйцэтгэлийн хяналтын картыг маягт №2<sup>2</sup>-ийн дагуу 2 хувь үйлдэж, нэг хувийг Хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн архивын нэгж болгон хадгална.

5.3.Барилгын ажлын явцын үе шат

5.3.1.Барилгын ажлыг гүйцэтгэх явцад Барилга захиалагчийн хэлтэс барилгын ажил үргэлжлэх хугацаа, чанар (ажлын, барилгын материалын чанар, өнгө, үзэмж, сонголт) ажлын гүйцэтгэлд гэрээний явцын хяналтыг гүйцэтгэж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

5.3.2.Барилгын ажлын явцын хяналтын үе шат бүрт хяналтын инженерүүд өөрийн мэргэшлийн хүрээнд албан тушаалын тодорхойлолтонд заасны дагуу хяналтыг тавьж ажиллана.

5.3.3.Хяналтын инженер Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, ажлын явцын мэдээллийг тухай бүр сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын цахим системд оруулах

5.3.4.Ажлын үе шатны мэдээллийг хөрөнгө оруулалтын ажлын мэдээллийн системд фото зургаар баяжуулан долоо хоног бүр оруулна.

5.3.5.Гүйцэтгэгчээс ирүүлсэн санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн бичиг баримтыг Маягт №2<sup>2</sup> “Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдэлийн дагуу НХОГ-ын Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн хүлээн авч ажлын 1 өдөрт багтаан хариуцсан хяналтын инженерт шилжүүлнэ.

5.3.6.Гэрээт ажил дуусгавар болох бүрт энэ журмын хавсралт Маягт №4<sup>2</sup> “Барилгын ажлын гэрээ дүгнэсэн протокол”-ын дагуу гэрээг дүгнэн протокол үйлдэнэ.

5.3.7.Хяналтын инженер энэ журмын хавсралт Маягт №3<sup>2</sup> “Барилгын ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”-ын дагуу ажлын 4 хоногт багтаан ахлах инженер, хэлтсийн дарга, Санхүү аж ахуйн хэлтэс, Хууль дотоод хяналтын хэлтэс, Ерөнхий инженерээр хянуулан баталгаажуулсныг газрын дарга албажуулна.

5.3.8.Гүйцэтгэл баталгаажих явцад засвар оруулах тохиолдолд хавсралт Маягт №7-ын дагуу хяналтын хуудас хөтлөн хяналтын инженер гүйцэтгэгчид буцаана.

5.3.9.Гүйцэтгэлийн хяналтын картыг Маягт №3<sup>2</sup>-ийн дагуу 2 хувь үйлдэж, нэг хувийг Хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн архивын нэгж болгон хадгална.

#### 5.4 Барилгын ажил дуусгах эцсийн үе шат

5.4.1.Барилгын ажил дуусч барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулна.

5.4.2.Гүйцэтгэгчээр барилгын ажлын гүйцэтгэлийг хөрөнгийн нэр, төрөл, тоо, хэмжээ тус бүрээр (тохижилтын ажлын хувьд тоглоом, хайс, хашаа, ногоон байгууламж г.м, барилгын ажлын хувьд барилга, инженерийн шугам сүлжээ-дулааны шугам, бойлер, насос, худаг, цэвэр усны шугам, бохир усны шугам; үерийн байгууламж-үерийн далан, борооны ус зайлуулах шугам, худаг, суваг; хашаа, тохижилт, барилгын дотор засвар, гадна засвар гэх мэт) гаргуулж, барилгын ажлын техникийн баримт бичгүүдийг бүрдүүлнэ.

5.4.3.Комиссын акт баталгаажсаны дараа хяналтын инженер, гүйцэтгэгчтэй хамтран барилга байгууламжийг ашиглагчид хүлээлгэн өгнө. Ашиглагч байгууллага тодорхойгүй бол Нийслэлийн Өмчийн харилцааны газарт мэдэгдэл хүргүүлнэ.

5.4.4.Энэ журмын 5.4.2-т заасан баримт бичгийг бүрдүүлсний дараа гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээг энэ журмын хавсралт Маягт №4<sup>2</sup> “Барилгын ажлын гэрээ дүгнэсэн протокол”-ын дагуу дүгнэж, санхүүжилтийн эцсийн тооцоог хийхээр гүйцэтгэлийн бичиг баримт бүрдүүлж, энэ журмын дагуу хянуулна.

5.4.5.Барилгын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ. Засгийн газрын 2021 оны Журам шинэчлэн батлах тухай 160 дугаар



тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”, энэ журмын хавсралт Маягт №2<sup>3</sup>-ийн дагуу НХОГ-ын Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн хүлээн авч ажлын 1 өдөрт багтаан хариуцсан хяналтын инженерт шилжүүлнэ.

5.4.6. Гүйцэтгэл баталгаажигдах явцад засвар оруулах тохиолдолд хавсралт Маягт №7<sup>1</sup>-ийн дагуу хяналтын хуудас хөтлөн хяналтын инженер гүйцэтгэгчид буцаан олгоно.

5.4.7. Хяналтын инженер энэ журмын хавсралт Маягт №3<sup>2</sup> “Барилгын ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”-ын дагуу ажлын 4 хоногт багтаан ахлах инженер, хэлтсийн дарга, Санхүү аж ахуйн хэлтэс, Хууль дотоод хяналтын хэлтэс, Ерөнхий инженерээр хянуулан баталгаажуулсныг газрын дарга албажуулна.

5.4.8. Гүйцэтгэлийн хяналтын картыг Маягт №3<sup>2</sup>-ийн дагуу 2 хувь үйлдэж, нэг хувийг Санхүүгийн мэргэжилтэн архивын нэгж болгон хадгална.

5.4.9. Комиссын акт баталгаажиж эцсийн санхүүжилтийг олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор хяналтын инженер барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгүүлэхээр хавсралт Маягт №5<sup>3</sup> “Барилгын ажлын техникийн бичиг баримтыг НӨХГ-т хүргүүлсэн акт”-ын дагуу бүрдүүлэн Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлж ажлыг дуусгах ба НӨХГ-т хүргүүлсэн актыг Санхүү, аж ахуйн хэлтэст хүлээлгэн өгнө.

5.4.10. Хяналтын инженер гэрээт ажил дуусгавар болсон улиралд багтаан техникийн баримт бичгийн бүрдлийг хавсралт Маягт №8<sup>2</sup> “Барилгын ажлын баримт бичгийн бүрдэл”-ийн дагуу бүрдүүлэн архивын нэгж болгон архивт хүлээлгэж өгнө.

### **Зургаа. Зохиогчийн хяналтын гэрээ, гүйцэтгэл**

6.1. Зохиогчийн хяналтын гэрээг Зохиогчийн хяналтын гэрээ байгуулах баримт бичгийн бүрдэл Маягт 1<sup>3</sup>-т заасны дагуу бүрдүүлж, Зохиогчийн хяналтын гэрээний карт-Маягт №3<sup>5</sup>-т дагуу албан тушаалтнууд гарын үсэг зурж гэрээг баталгаажуулна.

6.2. Зураг төсөвтэй зарлагдсан барилга угсралтын ажилд Хяналтын инженер барилга угсралтын ажлын гэрээг хүлээн авч тухайн объектын зохиогчийн хяналтын гэрээг маягтад заасны дагуу бэлтгэж зохиогчид хүргүүлнэ.

6.3. Хяналтын инженер Барилга угсралтын явцад ажлын зурагт өөрчлөлт гарах, үүнтэй уялдан төсөвт өртөгт өөрчлөлт орсон тохиолдолд зохиогчоор заавал баталгаажуулна.

6.4. Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг байгуулахдаа зураг төслийн хэлтэстэй хамтран байгуулах бөгөөд зураг төсөл боловсруулах явцыг Зураг төслийн хэлтэс хариуцан хэрэгжүүлнэ. Зураг төсөл батлагдсаны дараа захиалагчийн хэлтсийн хяналтын инженер хүлээн авч, тендэрт ирүүлсэн ажлын тоо хэмжээг дахин шалгаж, зохиогчийн хяналтын гэрээ байгуулан ажиллана.

6.5. Гэрээг сунгах тохиолдолд холбогдох материалуудыг бүрдүүлэн Маягт 3<sup>5</sup>-д заасны дагуу гарын үсэг зурж баталгаажуулна.

6.6. Зохиогчид санхүүжилт олгоходоо Маягт №2<sup>4</sup> дагуу материал бүрдүүлж гэрээ дүгнэсэн протокол үйлдэж дүгнэнэ.

**Долоо. Барьцаа хөрөнгө чөлөөлөх**

7.1.Барьцаа хөрөнгө чөлөөлөх баримт бичгийн бүрдэл Маягт №2<sup>5</sup>-д заасан материалыг бүрдүүлж Маягт №4<sup>1</sup>, Маягт №4<sup>2</sup> дагуу гэрээ дүгнэж барьцааг чөлөөлнө.

7.2.Барьцаа хөрөнгө чөлөөлөхдөө тооцооны үлдэгдлийн баталгааг Маягт№ 9-ийн дагуу баталгаажуулна.

### **Найм.Ахлах инженерүүд, хэлтсийн дарга нарын үүрэг оролцоо**

8.1.Барилгын ажлын явцын хяналтын үе шатанд бүсийн болон ахлах инженерүүд хяналтын инженерүүдийн хоорондын уялдаа холбоо, өдөр тутмын удирдлагаар ханган асуудлыг шийдвэрлэнэ.

8.1.1.Ахлах инженер хяналтын инженерийн хянасан гүйцэтгэлийн баримт бичгийг хянан энэ журмын Маягт №3<sup>1</sup> “Зураг төслийн ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”, Маягт №3<sup>2</sup> “Барилгын ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”-дээр ажлын 1 хоногт буюу тухайн өдөрт нь багтаан гарын үсэг зурж баталгаажуулна.

8.1.2.Гүйцэтгэл баталгаажигдах явцад засвар оруулах тохиолдолд хавсралт Маягт №7<sup>1</sup>-ийн дагуу хяналтын хуудас хөтлөн ахлах инженер хяналтын инженерт буцаан олгоно.

8.1.3.Ахлах инженер гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээ дуусгавар болсон мөн санхүүжилттэй холбоотойгоор хяналтын инженерийн гэрээ дүгнэсэн протоколыг Маягт №4<sup>1</sup> “Зураг төсвийн ажлын гэрээ дүгнэсэн протокол” , Маягт №4<sup>2</sup> “Барилгын ажлын гэрээ дүгнэсэн протокол” -ын дагуу хянан гарын үсэг зурж баталгаажуулна.

8.2.Барилгын ажлын явцын хяналтын үе шатанд хэлтсийн дарга нь ахлах инженерүүд болон хяналтын инженерүүдийн хоорондын уялдаа холбоог зохицуулан, холбогдох байгууллагаас шалтгаалсан асуудлыг мэргэжлийн хүрээнд шийдвэрлэнэ.

8.2.1.Хэлтсийн дарга ахлах инженерийн хянасан гүйцэтгэлийн баримт бичгийг хянан энэ журмын Маягт №3<sup>1</sup> “Зураг төслийн ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”, Маягт №3<sup>2</sup> “Барилгын ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”-дээр ажлын 1 хоногт буюу тухайн өдөрт нь багтаан гарын үсэг зурж баталгаажуулна.

8.2.2.Гүйцэтгэл баталгаажигдах явцад засвар оруулах тохиолдолд хавсралт Маягт №7<sup>1</sup>-ийн дагуу хяналтын хуудас хөтлөн хэлтэсийн дарга ахлах инженерт буцаан олгоно.

8.2.3.Хэлтсийн дарга гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээ дуусгавар болсон мөн санхүүжилттэй холбоотойгоор ахлах инженерийн хянасан гэрээ дүгнэсэн протоколыг Маягт №4<sup>1</sup> “Зураг төсвийн ажлын гэрээ дүгнэсэн протокол” , Маягт №4<sup>2</sup> “Барилгын ажлын гэрээ дүгнэсэн протокол” -ын дагуу хянан гарын үсэг зурж баталгаажуулна.

8.3.Барилгын ажлын явцын хяналтын үе шатанд Ерөнхий инженер нь хэлтэсүүдийн уялдаа холбоог зохицуулан, холбогдох байгууллагаас шалтгаалсан асуудлыг мэргэжлийн хүрээнд шийдвэрлэн шаардлагатай бүхий арга хэмжээг авч ажиллана.

8.3.1.Ерөнхий инженер хэлтэсийн даргын хянасан гүйцэтгэлийн баримт бичгийг хянан энэ журмын Маягт №3<sup>1</sup> “Зураг төслийн ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”, Маягт №3<sup>2</sup> “Барилгын ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”-дээр ажлын 1 хоногт буюу тухайн өдөрт нь багтаан гарын үсэг зурж баталгаажуулна.

8.3.2. Гүйцэтгэл баталгаажигдах явцад засвар оруулах тохиолдолд хавсралт Маягт №7<sup>1</sup>-ийн дагуу Хяналтын хуудас хөтлөн ерөнхий инженер хэлтсийн дарга нарт буцаан олгоно.

8.4. Санхүү аж ахуйн хэлтэс гүйцэтгэгчээс ирүүлсэн санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн баримт бичигт өмнө авсан санхүүжилт таарч байгаа эсэх, арфиметик алдаа байгаа эсэх, гэрээний иж бүрдэлд ирүүлсэн банкны баталгааны үнэн зөв эсэх, хөрөнгийн захирамж, санхүүжилтын хуваарийн дагуу байгаа эсэхийг болон гэрээний үнийн дүн түүнд заагдсан захиалагчийн техник хяналтын зардлын дүнг шалгаж энэ журмын Маягт №3<sup>1</sup> “Зураг төслийн ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”, Маягт №3<sup>2</sup> “Барилгын ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”-дээр ажлын 1 хоногт буюу тухайн өдөрт нь багтаан гарын үсэг зурж баталгаажуулна.

8.4.1 Гүйцэтгэл баталгаажигдах явцад засвар оруулах тохиолдолд хавсралт Маягт №7<sup>1</sup>-ийн дагуу хяналтын хуудас хөтлөн санхүү аж ахуйн хэлтэс хяналтын инженер болон ахлах инженерт буцаан олгоно

8.5. Барилгын ажлын явцын хяналтын үе шатанд Хууль, дотоод хяналтын хэлтэс гүйцэтгэгчээс ирүүлсэн санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн бичиг баримтыг үнэн зөв хянасан эсэхийг энэ журмын Маягт №3<sup>1</sup> “Зураг төслийн ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”, Маягт №3<sup>2</sup> “Барилгын ажлын гүйцэтгэлийн хяналтын карт”-дээр дотоод хяналтын тэмдэгээр ажлын 1 хоногт буюу тухайн өдөрт нь багтаан баталгаажуулж гарын үсэг зурна.

8.5.1. Гүйцэтгэл баталгаажигдах явцад засвар оруулах тохиолдолд хавсралт Маягт №7<sup>1</sup>-ийн дагуу Хяналтын хуудас хөтлөн санхүү аж ахуйн хэлтэс хяналтын инженер болон ахлах инженерт буцаан олгоно.

### **Ес.Хариуцлага**


9.1. Энэхүү журамд зааснаас бусад харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

9.2. Энэхүү журмыг зөрчсөн албан хаагчийн үйлдэл эс үйлдэхүй, хохирлын хэмжээнээс шалтгаалж байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



Маягт-1<sup>1</sup>

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын  
2023 оны 04 дугаар сарын 03-ны өдрийн  
01/38 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**ЗУРАГ ТӨСВИЙН АЖЛЫН ГЭРЭЭНИЙ БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ**

Ажлын нэр:.....


Гэрээний дугаар:.....

Компани:.....

д/д	Баримтын нэр	+/-	Тавигдах шаардлага	Тайлбар
1	Гэрээний хяналтын хуудас			
2	Гэрээ		Батлагдсан маягтын дагуу байх, гэрээнд дардас дарахгүй, гүйцэтгэгчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтанаар гарын үсэг зуруулж баталгаажуулах, Үнийн дүн, ажлын нэр, ажил эхлэх дуусах хугацаа зэргийг зөв бичигдсэн эсэхийг шалгана. (Гэрээний нэр, дугаар нь зөвлөмж, хөрөнгийн захирамжийн нэртэй тохирч байх ёстой) Гэрээний хойно бичигдэх гүйлгээ хийх данс нь компаний гэрчилгээний хойно бичигдсэн данс байх	Эх хувь
3	Хөрөнгийн захирамж		Тухайн ажлын хөрөнгийн захирамж мөн эсэхийг анхаарна (хөрөнгийн задаргаа ажлын нэрийг тулгана)	Хуулбар хувь
4	Зөвлөмж		Захирамжийн нэртэй зөрөхгүй байх, Бүх гишүүд гарын үсэг зурагдсан байх	Хуулбар хувь
5	Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл		Шууд гэрээ байгуулахаас бусад тохиолдолд ажлын 5 хоногийн дараа гэрээ байгуулагдаж буй эсэхийг анхаарна. (Албан бичиг гарсан огнооны дараа өдрөөс эхлэн нэг хоног гэж тооцож ажлын 6 хоногийн дараагаас гэрээ байгуулна)	Эх хувь
6	Гэрээний тусгай нөхцөл		Гэрээний ерөнхий нөхцөлийн заалттай уялдаж буйг тулгана. (ажлын нэр, эхлэх дуусах хугацаа зөв бичигдсэнийг, алданги торгууль тооцох эсэх, үнийн тохируулга хэрэглэх эсэх, нөхөн төлбөр олгох эсэх, үе шатны санхүүжилт хэрхэн авахаар тусгасаныг сайн анхаарах)	Эх хувь
7	Архитектур төлөвлөлтийн даалгавар		Барилгын зурагт шаардлагатай	Хуулбар хувь
8	Зураг төсөв боловсруулах даалгавар		Барилга болон инженерийн шугам сүлжээний ажилд шаардах	Хуулбар хувь
9	Ажил гүйцэтгэх хуваарь		Гэрээнд заасан хугацаанд багтаж байгаа эсэхийг шалгана. (заавал гэрээний хугацаанд эхлэж дууссан байхаар хийж ирсэн байна. Гэрээнээс өмнө эхлэх болон гэрээ дуусахаас өмнө дуусахаар хийсэн байж болохгүй)	Эх хувь
10	Гүйцэтгэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн хамт		Тусгай зөвшөөрлийн хүчинтэй эсэхийг шалгана.	Хуулбар хувь

11	Гүйцэтгэлийн баталгаа		100 сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй шаардана (батлагдсан маягтын дагуу байх/ /хоног заасан бол гэрээ дууссанаас хойш 28 хоног байхаар тооцож авна)	Эх, хуулбар хувь
12	Бусад шаардлагатай баримт бичиг		Үнэлгээний хороо байгуулсан захирамж, Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, тайлан	Хуулбар хувь
13	Гэрээний ерөнхий нөхцөл		Ямар нөхцөлтэй гэрээ зарлаж байгаагаас гэрээний ерөнхий нөхцөл өөр өөр байна. (түлхүүр гардуулах болон харьцуулалтын тендер гм)	Эх хувь
1	Нийт хуудас			

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын  
 2023 оны 09 дугаар сарын 03-ны өдрийн  
 1/56 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ  
 БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ**

Ажлын нэр:.....  
 Гэрээний дугаар:.....  
 Гүйцэтгэгч байгууллагын нэр:.....


№	Баримтын нэр	+/-	Тавигдах шаардлага	Тайлбар
1	Гэрээний хяналтын хуудас			
